Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны 02 дугаар сарын 01 өдрийн 03/44 тоот албан бичгийн хавсралт

## Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2021 оны жилийн эцэс биелэлт

| Д/д | Үйл ажиллагаа | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хоёр дахь үе шат ( 2020 - 2023) хүрэх түвшин , үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | 4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | 2017 - 2022 | | 1. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлтийн мэдээллийн санг хөгжүүлсэн байх 2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн системийг хөгжүүлсэн байх | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс Хувийн ашиг сонирхлын урдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг гаргуулан Авлигатай тэмцэх газарт хянуулахаар тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. 2021 онд нийт 18 ХАСУМ хянуулахаар мэдүүлснээс төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдохоор 9, түр орлон гүйцэтгэгчээр томилохоор 5, шатлан дэвшиж томилогдлохоор 4 нэр дэвшигчийн ХАСУМ-ийг тус тус хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Үүнээс ашиг сонирхлын зөрчилтэй дүгнэлт ирээгүй болно. Үндэсний хөгжлийн газрын Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг Үндэсний хөгжлийн газрын info@nda.gov.mn веб сайтын авлигын эсрэг үйл ажиллагаа хэсгийн ХАСУМ дүгнэлт гэсэн хэсэгт оруулан олон нийтэд ил тод нээлттэй болгосон. Эрх бүхий албан тушаалтан ХАСУМ мэдүүлгийг тухай бүр meduuleg.iaac.mn системд оруулж, бүртгэлийг хөтөлсөн. | 100% |
| 2 | | 5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, | 2017 - 2022 | | Хүний нөөцийн системтэй уялдсан "Төрийн албаны хүний нөөцийн ил | Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн,Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | | | тод байдлын мэдээллийн сан"-г хөгжүүлсэн байх | нээлттэй болгох хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам загвар батлах" тухай 17 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 5 дугаар хавсралтын дагуу 2021 оны 1 сарын 29-ний өдрийн 01/69 тоот албан бичгээр, 2021 оны 6 сарын 30 өдрийн 01/415 тоот албан бичгээр хүний нөөцийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан, мэдээг тус тус хуулийн хугацаанд Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулан тайлагнаж байна. | |
| 3 | 4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | 1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2022 | | 1. Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байх 2. Шалгуурт нийцсэн ТЖАХ-ийн эзлэх хувь - 70%-аас дээш | Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд нийтэд зарлах, Төрийн албаны зөвлөлд мэдээлэх ажлыг тухай бүр хэрэгжүүлж байна. /Төрийн албаны зөвлөлд 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01/56 тоот албан бичиг, 2021 оны 04 сарын 29-ний өдрийн 01/273 тоот албан бичгээр сул орон тоо гарсан тухай мэдээлсэн/. Мөн шилэн дансны тухай хуулийн 6.4.7-т заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээг сар бүрийн 8-ний дотор хугацаа хоцроохгүй олон нийтэд мэдээлж ил тод болгосон.<br>- Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 168, 169, 170 дугаар тушаалуудаар албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрлийг олгосон. Газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн А-60 дугаар тушаалаар албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталсан.<br>Ковидын цар тахалтай холбоотойгоор улсын онцгой комиссоос ирүүлсэн албан бичгийн дагуу Төрийн албаны зөвлөлөөс тухайн албан тушаалын тусгай шалгалтууд 2021 оны 2 сараас хойш тодорхойгүй хугацаагаар зарлагдаагүй.<br>Газрын даргын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 01/499 тоот албан бичгээр тусгай шалгалт зарлуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн боловч тусгай шалгалт зарлагдаагүй. Иймд сул болон эзгүй байгаа орон тоог ажлын зайлшгүй шаардлагын үндсэн дээр сэлгэн ажиллуулах,шилжүүлэх, төрийн албаны нөөцөд байгаа тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан иргэдээс сонгон авч түр орлон гүйцэтгүүлэх болон гэрээ байгуулж ажиллуулах хэлбэрээр хуулийн хүрээнд албан хаагчийг томилон, ажил үүргийг нь гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | 1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох | 2017 - 2022 | | Албан бичиг цахим орчинд баталгаажиж, мэдээлэл солилцох мэдээллийн систем бий болсон байх | Тус байгууллагын албан хэрэг хөтлөлтдөө ашигладаг програм болох intranet.gov.mn нь нийтийн түлхүүр үг /e-token/ ашиглан нэвтрэх дэд бүтэц хангагдсан. | 100% |
| 5 | | 2.Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах | 2018 - 2022 | | Байгууллагуудын мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн байх | Тус байгууллага нь Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд холбож, УБЕГ, ТЕГ, НДЕГ ГИХЕГ -уудтай гадаадын хөрөнгө оруулагч нарт зориулсан нэг цэгийн үйлчилгээг цахимаар хэлбэрээр явуулахад ашигладаг invest-assist.gov.mn системийг хөгжүүлэн нэгдсэн сан бүрдүүлж ажиллаж байна. | 100% |
| 6 | 4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд: | 2018 - 2022 | | Хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувь буюу 36387 албан хаагчийг давтан сургасан байх | Авлигатай тэмцэх газрын авлигын эсрэг үйл ажиллагааны сургалтад үндэсний хөтөлбөрийн хүрээнд явуулсан Удирдах албан тушаалтанд зориулсан -1, Хуулийн мэргэжилтэнд зориулсан 1, ЭБАТ зориулсан 1, Шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан 15, сургалтуудад нийт 18 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 2. Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 7 | 4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 2018 - 2022 | | Сүлжээний хэвийн ажиллагааг хангасан байх | Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагааг бэхжүүлж, “Цахим нэг цонхны үйлчилгээ” нэвтрүүлж, хөгжүүлэх хүрээнд хөрөнгө оруулагчийн оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг Хөрөнгө оруулалтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад дүрэм журмыг баримтлан www.invest-assist.gov.mn системээр цахимаар олгож эхэлсэн. Уг зөвшөөрлийн хүсэлт өмнө нь уламжлалт хэлбэрийн цаасаар ажлын 3 хоногт гардаг байсан бол систем ашиглалтад орсноор ажлын 8 цагт цахимаар олгож байна. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д төрийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлж, үйлчилгээний шийдвэрлэх хугацааг багасгах, хөрөнгө оруулагчдад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тулгардаг хүндрэлийг арилгах, илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Дэлхийн банк групптэй хамтран Цахим нэг цонхны системийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд e-invest системийг ашиглалтад оруулснаар гадаадын хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг цахимаар олгож эхэлсэн байна. | |
| 8 | 4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2018 - 2022 | | Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг ТББ-д шилжүүлсэн байх | Хөрөнгө оруулалтын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш татварын орчин, хувь хэмжээг тогтворжуулахаар 2022 оны байдлаар нийт 17 хуулийн этгээдэд Тогтворжуулах гэрчилгээг олгосон байна. Хөрөнгө оруулалтын гэрээ болон гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн зөвшөөрөл авах хүсэлт шинээр ирүүлээгүй болно. | 100% |
| 9 | 4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын | 3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх | 2018 - 2022 | | Хяналт шалгалтын тоог цөөрүүлсэн байх | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь санхүүгийн аудит, нийцлийн аудит, дотоод хяналт шалгалтыг төлөвлөхдөө эрсдлийн үнэлгээнд суурилан давтамжийн хуваарийг гаргадаг. 2021 онд санхүүгийн аудит хийгдээгүй ба байгууллагын архивын үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, архивын үйл ажиллагаа, архивын нэгжийн нөхөн бүрдүүлэлт, данс бүртгэл болон архивт хадгалагдаж буй бусад хадгаламжийн нэгжийн мэдээллийг хамруулсан. Шилэн дансны мэдээллийн явцад урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог боловсронгуй болгох | | | | | | |
| 10 | 4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | 1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | 2017 - 2022 | | Үнэлгээ хийлгэх ажил хэвшсэн байх | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг 2 удаа зохион байгуулсан бөгөөд 2018 онд Эс Ай Си Эй" ХХК, 2019 онд Эм Эм Си Жи ХХК тус тус гүйцэтгэсэн. 2019 онд улсын хэмжээнд буюу 4 аймаг болон УБ хотын 354 респондент болон 47 ААНБ-ыг хамруулсан. Үнэлгээний үр дүнг чанартай, бодитой, итгэх түвшнийг өндөр байлгахын тулд иргэд, албан байгууллагуудаар CAPI аргаар мэдээлэл цуглуулахдаа ашигласан.<br><br>Судалгаанд оролцогчид 3.25 гэсэн үнэлгээг өгсөн ба дунджаас бага зэрэг дээгүүр үнэлсэн. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид сэтгэл ханамжтай байгаа хэдий ч хэрэглэгчтэй холбоотой зарим үзүүлэлт, индикаторыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Оролцогчдоор ялгаж харвал иргэд 3.10, байгууллагууд 3.41 гэж үнэлсэн.<br><br>2019 оны хамгийн үр дүнтэй ажлыг иргэд "Нэг цэгийн үйлчилгээ" гэж үзсэн бол байгууллагууд сургалт, семинар,хэлэлцүүлэг гэж үзсэн ба байгууллагуудын хувьд концессын төслийн хүрээнд хэрэгжиж байгаа ажлуудад хамгийн их оролцоотой байжээ. Үндэсний хөгжлийн газрын бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагууд газрын цахим хуудаснаас, иргэд телевиз, радиогоос авч байна.<br><br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.6-д ЗГХЭГ нь хэрэглэгчийн үнэлгээг бүх аймаг нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулах, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулахаар заасан. | 100% |
| 11 | | 2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх | 2018 - 2019 | | | Тус газрын зүгээс гадаадын хөрөнгө оруулагчдад олгох тодорхойлолтыг цахимаар олгож үйлчилгээ үзүүлдэг. Тайлант хугацаанд уг үйлчилгээ авсан иргэдээс санал, хүсэлтийн буланг байршуулан ажилласан болно. Түүнчлэн үйл ажиллагааны шилэн дансаар дамжуулан хүний нөөцийн мэдээлэлтэй танилцах боломжтой болно. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд Үндэсний хөгжлийн газар нь шударга байдлын үнэлгээ хийсэн хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэн, иргэдээс мэдээлэл авах үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, уг үнэлгээгээр тус газар нь бусад төрийн байгууллагуудыг тэргүүлсэн болно. | | |
| 3. Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | | |
| 12 | 4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох | 1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах | 2017 - 2019 | | | Тусгай сан байхгүй тул хэрэгжилтийг тайлагнах боломжгүй. | Үнэлэх боломжгүй | |
| 13 | | 2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх | 2017 - 2020 | | Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээллэдэг болсон байх | Тусгай сан байхгүй тул хэрэгжилтийг тайлагнах боломжгүй. | Үнэлэх боломжгүй | |
| 14 | 4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | 1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах | 2017 - 2022 | | Төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгаж хэвшсэн байх | Чиг үүрэгт хамааралгүй | Үнэлэх боломжгүй | |
| 15 | | 2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com | 2018 - 2022 | | Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангасан байх | Чиг үүрэгт хамааралгүй | Үнэлэх боломжгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх | | | | | |
| 16 | 4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | 2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2019 | | | 2020 оны Санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт авсан. | 100% |
| 4. Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 17 | 4.1.4.4. Концесс, шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох | 2. Концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгосон журам боловсруулах | 2017 - 2018 | | | Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2021.1.1-ээс чиг үүрэг шилжсэн | Үнэлэх боломжгүй |
| 18 | | 3. Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах | 2017 - 2019 | | | Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2021.1.1-ээс чиг үүрэг шилжсэн | Үнэлэх боломжгүй |
| 6. Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх | | | | | | | |
| 19 | 4.1.6.2. Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг | 2. Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг | 2018 - 2022 | | Төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байх | Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага (JETRO), Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын санхүүгийн корпораци, “Ирбис Венчурс” компанитай хамтран “Invest in Mongolia - Tokyo 2021” Монгол-Японы бизнес форумыг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулсан. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн заагийг тодорхойлох | судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх | | | | Форумд танилцуулагдсан төслүүдийг "Төсөл чадавхижуулах хөтөлбөр"-т хамрагдуулж, Үндэсний хөгжлийн газар /хуучин нэрээр/-ын зүгээс төсөл хэрэгжүүлэгч 10 компанид гадаадын хөрөнгө оруулагчдад төслийг сурталчлах, бэлэн байдлыг хангах цогц сургалтыг орж, хувийн хэвшлийн төслүүдийг чадавхжуулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх зөвшөөрлийг олгох зохицуулалттай. Монгол Улсын эрх ашиг, төсөв санхүү, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлууд судлагдаж, яригддаг учир үүнийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй байдаг. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Үндэсний хөгжлийн газар нь газрын дэргэдэх төр-хувийн хэвшлийн оролцоог хангасан Тогтворжуулах гэрчилгээ олгох эсэх дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Тогтворжуулах гэрчилгээ олгох ажил явагдаж байна. Тогтворжуулах гэрчилгээ олгох шийдвэр нь Төр-хувийн хэвшлийн хамтын шийдвэрээр явагддаг болно. Мөн Гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлж буй Гадаадын хөрөнгө оруулагчидад түр оршин суух виз олгож өгөхийг хүссэн хүсэлт нь төрөөс үзүүлж буй дэмжлэгийн хэлбэр юм. | |
| 20 | 4.1.6.3. Төр, хувийн хэвшлийн болон хувийн хэвшил хоорондын авлигаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, аливаа санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах | 1. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх | 2018 - 2022 | | Хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжсэн байх | Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2021 оны 1 сарын 1-нээс концесс төр, хувийн хэвшлийн чиг үүрэг шилжсэн. | Үнэлэх боломжгүй |
| 21 | | 2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион | 2017 - 2018 | | | 2021 онд Үндэсний хөгжлийг газраас хувийн хэвшилтэй гэрээ байгуулагдаагүй болно. Цаашид төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах болно. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллалтын арга хэмжээг авах | | | | | |
| 22 | 4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах | 4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | 2018 - 2020 | | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажил хэвшсэн байх | Чиг үүрэгт хамааралгүй | Үнэлэх боломжгүй |
| 7. Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих | | | | | | | |
| 23 | 4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | 1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх | 2017 - 2019 | | | 2019 онд хэрэгжилт дууссан арга хэмжээ тул 2021 онд тайлагнах ажил хийгдээгүй байна. | 100% |
| 24 | | 2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх | 2018 - 2022 | | Жагсаалтад дурдсан төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн байх | Шилэн дансны мэдээллийг тухай бүр хуулийн хугацаанд мэдээлж ажилласан болно. | 100% |
| 25 | | 3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээлэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах | 2020 - 2022 | | Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирсан байх | Тайлант хугацаанд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр ТББ-аар гүйцэтгүүлээгүй болно. | Үнэлэх боломжгүй |
| 10. Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх | | | | | | | |
| 26 | 4.1.10.1. Авлигын | 4. Төрийн байгууллагуудын | 2017 - 2022 | | Төрийн байгууллагуудын | 2021 онд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан биелэлтийг хагас болон бүтэн жилээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах | | | Шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх | тайлагнасан. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас хуудсандаа байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарт сар бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4; 6.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг хуульд заасан хугацаанд тайланг байгууллагын албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангаж ажиллаж байна. | |
| 27 | 4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх | 2017 - 2022 | | Сургагч багш нарыг үе шаттайгаар сургаж, сургагч багшийн тоог нэмэгдүүлсэн байх | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургагч багш бэлтгэх сургалтад хамруулахаар 2021 онд 2 албан хаагчийн нэрийг хүргүүлэн ажилласан. | 100% |